



МӨНГӨНМОРЬТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

2013 оны Санхүүгийн Тайлан

Үндэсний Аудитын газрын харьяа Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна. Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Дарга, Тэргүүлэх аудитор
Л.Жаргалсайхан
Утас: 70272582

Аудитын менежер
О.Амаржаргал
Утас: 70273463

Шинжээч Ц.Хишигжаргал
Утас: 70273204
И-мэйл khj_616@yahoo.com

Хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг
Төрийн байгууллагуудын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

- Танилцуулга 3
- Санхүүгийн дотоод хяналт 3-5
- Гол шийдлүүд 6
- Залруулаагүй алдаа... 6
- Тайлбар мэдүүлгийн захидал.... 6
- Аудитын санал дүгнэлт..... 6

Мөнгөнморьт сумын ЭМТөвийн 2013 оны Санхүүгийн Тайланд**ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Мөнгөнморьт сумын ЭМТөвийн 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байна. Мөнгөнморьт сумын ЭМТөвийн төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаах бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Мөнгөнморьт сумын удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулвал:**

Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг торуулвал:

Дотоод хяналт шалгалтын ажлыг үр дүнтэй хийгээгүй байна.

- ✓ Галын түлээнд илүү зарцуулсан 590.0 мянган төгрөгийг тухайн шийдвэрийг гаргасан албан тушаалтан буюу эрхлэгчээр төлүүлэх
- ✓ Данс бүртгэлд байхгүй 100м³ галын түлээний зарцуулалт болон үлдэгдлийг тооцон гаргаж данс бүртгэлд тусгах албан шаардлага бичив.
- ✓ Нярав тогооч нараар 116578 төгрөгийг хувь тэнцүүлэн төлүүлэх акт бичив.
- ✓ Томилолтын зардлын 84.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх акт бичив.
- ✓ ЭЭСангийн үйл ажиллагааны журамд тусгагдсантай нийцэхгүй байгаа тул дээрх 2838.8 мянган төгрөгийг ЭМТөвөөр төлүүлэх

ЕМ, Санхүүгийн албанаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү.

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд бараа материал бэлтгэж тайлагнахтай холбогдон гарсан зөрчлүүдийг арилгуулахаар албан шаардлага бичиж тус тайланд ЭЭСангийн хувьд хязгаарлалттай дүгнэлт гаргахаар Тэргүүлэх аудиторт санал оруулсан байгаа

Тэргүүлэх аудитор 2014.03.18-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч
Б.Анхбаяр нар бидэнтэй хамтран ажиллаж
бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ
талархаж байна.

Үндэсний Аудитын Газрын Харьяа Төв
Аймгийн Аудитын Газар

2014.03.16

Танилцуулга

1. Бид Мөнгөнморьт сумын ЭМТөвийн 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байна. ЭМТөвийн удирдлагуудад аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Мөнгөнморьт сумын ЭМТөвийн удирдлагууд тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

3. ААГазар нь санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Мөнгөнморьт сумын ЭМТөвийн дотоод хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Мөнгөнморьт сумын ЭМТөвийн удирдлагад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.
4. Дараах түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Мөнгөнморьт сумын ЭМТөвийн удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Санхүүгийн дотоод хяналт шалгалтын талаар

МУ-ын ЗГазрын 2011.11.09-ний өдрийн 311-р тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам батлагдсан байна. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” –ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө гэсэн заасан байдаг.

Жилийн эцэст дотоод хяналтын шалгалт хийгдсэн тухай тайлан авчраагүй ба хяналтын комисс томилсон тушаал гараагүй төлөвлөгөө боловсруулан батлуулаагүй байна.

- ✓ 2011.11.09 –ний өдрийн 311-р тогтоолыг хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг зөрчсөн албан тушаалтанд ногдуулах арга хэмжээ авхуулах санал хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Орлого санхүүжилтийн талаар

Мөнгөнморьт сумын ЭМТөв нь 2013 онд төсвөөс санхүүжүүлсэн 190888.1 мянган төгрөг үндсэн бус үйл ажиллагааны орлог 320.0 мянган төгрөг нийт 191208.1 мянган төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулсан байна. өөрийн орлого 320.0 мянган төгрөг нь төлбөрт үйлчилгээний орлого байна. Санхүүжилтын орлогыг тайланд зөв бүртгэж тусгасан байна.

3.Үндсэн хөрөнгө

ЭМТөвийн үндсэн хөрөнө нь оны эхэнд 435001.2 мянган төгрөг дээр 2598.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, хасагдсан хөрөнгө байхгүй 437599.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Үүнд: Тоног төхөөрөмж дансанд 939.0 мянган төгрөгийн үнэ бүхий 1ш нөүтбүүк, 350.0 мянган төгрөгийн өнгөт принтер нийт 1289.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

Мөн ХӨСҮТөвөөс шилжиж ирсэн 1309.7 мянган төгрөгийн үнэ бүхий вакцины хөргөгчийг тус дансанд үнэ төлбөргүй шилжиж ирсэн гэж бүртгэсэн байна. Тайлант онд үндсэн хөрөнгөнд нийт 19765.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулж зардалд тусгасан байна. Жилийн эцэст үнсэн хөрөнгийн тооллого хийсэн гэх боловч тооллогын комисс гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

✓ Урсгал зардалаас 1289.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

4.Бараа материал.

Тайлант онд бараа материалын тайлангаар 22936.8 мянган төгрөгийн орлогын, 24310.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж жилийн эцэст 17630.4 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Бараа материалын дансаар бичиг хэргийн материал 837.1 мянган төгрөг худалдан авч 770.7 мянган төгрөг зарцуулсан, аж ахуйн материалд 1601.4 мянган төгрөгийн орлого авч 1219.5 мянган төгрөг зарцуулсан, түлш шатах тослох материалд 8529.0 мянган төгрөгийн орлого авч 7788.5 мянган төгрөгийн шатахууны зардал гарсан, хүнсний материал 3760.6 мянган төгрөгийн орлого авч 3990.5 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулсан, эм боох материалд 6056.6 мянган төгрөгийн орлого авч 6236.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Түлш халаалтын зардалд галын түлээний модыг бараа материалын дансаар дамжуулан орлого авч зарцуулдаг ба тайлант онд байгууллагын ажилчдын хүчээр 100м3 галын түлээ бэлтгэхэд гоожингийн үнэ 425.0 мянган төгрөг, шатахуунд 768.5 мянган төгрөг, ажлын хөлсөнд 900.0 мянган төгрөг, хүнсэнд 296.4 мянган төгрөг нийт 2389.9 мянган төгрөг зарцуулж 1м3 галын түлээний үнэ 23900 төгрөг болсон байна. Тус суманд иргэд, аж ахуйн нэгжүүд 1м3 галын түлээг 18.0 мянган төгрөгөөр худалддаг ба өөрсдийн хүчээр бэлтгэсэн гэх галын түлээнд илүү зарцуулсан үнийн зөрүү 590.0 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан байна. Мөн тухайн 100м3 галын түлээ нь бараа материалын дансанд бүртгэлгүй зарцуулалт болон үлдэгдлийг хянах боломжгүй байна. Жилийн эцэст бараа материалын тооллого хийх байгууллагын даргын тушаал гараагүй, тооллого хийгээгүй байна.

- ✓ Галын түлээнд илүү зарцуулсан 590.0 мянган төгрөгийг тухайн шийдвэрийг гаргасан албан тушаалтан буюу эрхлэгчээр төлүүлэх
- ✓ Данс бүртгэлд байхгүй 100м3 галын түлээний зарцуулалт болон үлдэгдлийг тооцон гаргаж данс бүртгэлд тусгах албан шаардлага бичив.

5.Цалингийн талаар

Цалингийн сан үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайлангаар тус байгууллагуудад нийт 136035.3 мянган төгрөг тайлагнагдсан байна. ажилчдын цалингаас ХАОАТатвар 10507.6 мянган төгрөг суутгасан боловч татварын хэлтэст 10670.1 мянган төгрөг шилжүүлж 162.5 мянган төгрөг илүү төлсөн, НДШимтгэл 13749.6 мянган төгрөг суутгасан боловч 13218.2 мянган төгрөг шилжүүлж 531.4 мянган төгрөг дутуу төлсөн, мөн байгууллагаас НДШимтгэл 15124.6 мянган төгрөг тооцож 512.4 мянган төгрөг дутуу төлсөн байна. Ажилчдын цалингийн картанд шилжүүлсэн 109302.1 мянган төгрөгийг цалингийн цэстэй

тулган шалгахад 109302.1 мянган төгрөг нь тохирч байна. ЭМТөвийн их эмч Б.Батчимэг нь эрхлэгчийн ажлыг хавсран гүйцэтгэж цалингийн 40% -иар цалинждаг боловч энэ нь ЗГазрын 1995-оны 96-р тогтоолыг зөрчиж илүү тооцогдсон байна. Иймээс ажил хавсарсаны нэмэгдлийг заавал 40%-иар биш тохирох хувь хэмжээгээр олгож сар бүрийн цалинд илүү олгосон 29970 төгрөг буюу 359642 төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт бичив. Цалинг бодож олгоход 2012 оны 78-р тогтоолоор батлагдсан цалингийн сүлжээг баримтлан ЗГазрын 2001 оны үндэслэн 90-р тогтоолын дагуу урамшууллыг зөв тогтоож олгосон байна.

- ✓ Цалингийн цэс болон цагийн бүртгэлд гарын үсэг зуруулж хэвшүүлэх
- ✓ Илүү олгосон нэмэгдэл хөлс болох 359642 төгрөгийг төлүүлэх акт бичив.

6.Бараа үйлчилгээний зардал

Бараа ажил үйлчилгээний зардал 35772.2 мянган төгрөг батлагдсан ба төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 41447.3 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнээс түлш халаалтын зардал 7835.5 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 6778.1 мянган төгрөг, эмийн зардалд 6028.3 мянган төгрөг, хоол хүнсний материалд 2878.2 мянган төгрөг зэрэг зардлууд голлох дүнг эзэлж байна. Жилийн эцэст үлдсэн 6808.8 мянган төгрөгийг төвлөрүүлэн шилжүүлж бараа үйлчилгээний зардлын дүнд тусгасан байна.

Хүнсний материалд мөнгөн гүйлгээний тайлангаар 2878.2 мянган төгрөг зарцуулсан ба Санхүүгийн үр дүнгийн тайлангаар 3461.6 мянган төгрөг зарцуулсан байна. Бараа материалын дансанд хүнсний материал 5673.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хоолны зардлыг өдөр бүрийн хоолны ордер болон хэвтэн эмчлүүлж байгаа хүмүүсийн тоотой тулган үзэхэд нийт 51 хүнээр буюу 116578 төгрөгийн хүнсний материалыг зардалд илүү тусгасан байна. Иймд дээрх 116578 төгрөгийг нярав, тогооч нараар хувь тэнцүүлэн төлүүлэхээр шийдвэрлэв. Аймгийн СТСХэлтэсээс зөвшөөрөл авч нөүтбүүк 1000 төгрөг, хоолны өглөг 350.0 мянган төгрөг, автомашины засвар үйлчилгээнд 1700.0 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан байна. Томилолтын зардалд нэр бүхий 4 хүний 2014 оны 1-р сард явсан томилолтыг тооцож мөнгийг олгосон байна. Энэ нь тухайн оны зардлаас хэмнэгдсэн гэж үзэж дээрх 84.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх акт бичив.

- ✓ Авто машинаар ажил гүйцэтгэсэн тухай тайлан тэмдэглэгээ жолоочийн замын хуудсанд тодорхой бичиж зардалд тусгаж байх.
- ✓ Нярав тогооч нараар 116578 төгрөгийг хувь тэнцүүлэн төлүүлэх акт бичив.
- ✓ Томилолтын зардлын 84.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх акт бичив.

7.Мөнгөн хөрөнгө

Тайлант онд байгууллагын харилцах болон кассаар 194427.2 мянган төгрөг зарцуулсанаас кассаар 3113.2 мянган төгрөг авч зарцуулсан байна. Энэ нь эмийн үнэнд 218.0 мянган төгрөг галын түлээ бэлтгэх ажлын хөлс болон хүнсний материалд 611.0 мянган төгрөг бусад уралдаан тэмцээн гэх мэтэд зарцуулсан ба зохих татварыг суутган авч татварын хэлтэст тушаасан байна. Кассаар дамжуулан зарцуулсан дээрх мөнгөнд бэлтгэн нийлүүлэгч байгууллага хувь хүмүүчийн мөнгө хүлээн авсан баримт нэг ширхэгч байхгүй зөвхөн зарлагын баримтуудыг хавсрагасан байгаа нь анхан шатны баримтын бүрдэл муу кассын няравын хариуцлаггүй байгааг харуулж байна. Оны эцэст харилцах дансанд 6808.8 мянган төгрөг үлдсэнийг онд нь багтааж татан төвлөрүүлсэн байна. Кассанд үлдэгдлээр тайлагнагдсан 7567-н төгрөг 96 мөнгийг кассын няраваар төлүүлж харилцах дансанд төвлөрүүлэх.

- ✓ Кассын тайлан болон анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна.
- ✓ Няраваар 7567.96 мөнгийг төлүүлж харилцах дансанд төвлөрүүлэх

8. Авлага, өглөгийн талаар

Тайлант онд 6139.2 мянган төгрөгийн авлага үүсгэж 6067.7 мянган төгрөгийг барагдуулсан 71.5 мянган төгрөгийн авлагатай тайлагнагдсан байна. Энэ нь Багануурын НХангамжид илүү төлсөн шатахууны үнэ болон НДХэлтсээс авах авлаг байна. Мөн цалин, НДШ, ХАОАТ зэрэгт нийт 176315.4 мянган төгрөг бусад бараа үйлчилгээнд 24975.2 мянган төгрөг нийт 201290.6 мянган төгрөгийн өглөг үүсгэж барагдуулсан байна. Тайлант онд харилцагч байгууллагууд болох НДХэлтэс, Татварын хэлтэс, Өнөр дэлгэрэх тулга ХХК, Дунд гурван баян ХХК, Багануурын НХБааз, Эрчим хүчний салбар зэрэг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлж гарсан гүйлгээг сар бүрээр тулган баталгаажуулсан байна. Жилийн эцсийн санхүүгийн тайланд 71.5 мянган төгрөгийн авлага тусгагдсан байна.

9. Эргэлтийн эмийн сангийн талаар

Эргэлтийн эмийн сангийн мөнгө хөрөнгийн эхний үлдэгдэл 2637.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1869.0 мянган төгрөг нь арилжааны банк дахь дансны хуулгатай тохирч байна. Тайлант онд нийт 8867.3 мянган төгрөгийн эм худалдан авч борлуулсан ба НДХэлтсээс эмийн хөнгөлтийн үнэ 2316.0 мянган төгрөг борлуулалт орлого 9765.4 мянган төгрөг буюу нийт 12081.4 мянган төгрөгийн орлого орж 3214.1 мянган төгрөгийн ашигтай ажилласанаас 3743.5 мянган төгрөгийн зардал гаргаж 529.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Эмийн үлдэгдэл оны эхэнд 4243.7 мянган төгрөг байснаас 5419.0 мянган төгрөг болж нэмэгдсэн байна.

Тайлант оны эцэст 153.6 мянган төгрөгийн авлагатай гэж тайлагнагдсан байна. Жилийн эцсийн тоолло хийсэн гэх боловч ямар үр дүнгүй программаас эмийн үлдэгдлийг хэвлэн авч байгаа дүнгээр буцаан шивсэн байна.

Эргэлтийн эмийн сангийн орлогоос хаягны үнэ 360.0 мянган төгрөг, лампний үнэ 154.0 мянган төгрөг, самбарын үнэ 200.0 мянган төгрөг, магдлангийн шалгалтанд бэлтгэх 950.0 мянган төгрөг, туёламж үйлчилгээнд 464.0 мянган төгрөг гэх мэт эмнэлгийн урсгал зардалтай холбоотой нийт 2128.8 мянган төгрөг зарцуулсан мөн 2013 оны 10-р сарын 17-ны өдрийн 66 тоот албан бичгээр ЭМГазрын дарга Ч.Алтантуулд албан бичиг хүргүүлж 710.0 мянган төгрөгийг ЭЭСангаас гаргуулан авч зарцуулах хүсэлт тавьсан ба уг бичигт ямарч хариу ирээгүй/ ЭЭСангийн удирдах зөвлөлийн өмнөөс ЭМГазрын дарга шийдвэр гаргах эрхгүй/ байхад дээрх мөнгийг дур мэдэн зарцуулсан байна. Энэ нь ЭЭСангийн үйл ажмллагааны журамд тусгагдсантай нийцэхгүй байгаа тул дээрх 2838.8 мянган төгрөгийг ЭМТөвөөр төлүүлэх акт бичив. Мөн С.Энхтүвшинд 2013 оны 6-р сарын 20-ны өдрийн дугааргүй тушаалаар олгосон нэг сарын цалинтай тэнцэх 489939 төгрөгийн урамшуулал олгосон байгаа нь ЭМТөвийн удирдлага нь өөрийн эрх хэмжээнээс хэтэрсэн шийдвэр гаргасан байгаа тул уг мөнгийг шийдвэр гаргасан албан тушаалтанаар төлүүлэхээр акт бичив.

2013 оны 1- сарын 30-нд УБ хотоос эм татахдаа шатахууны мөнгө гаргуулж өөрийн унаатай явсан боловч унааны мөнгө гэж 32.0 мянган төгрөг, мөн 7-р сарын 18нд унааны мөнгө 29.0 мянган төгрөг нийт 61.0 мянган төгрөгийг давхардуулан авсан тул уг зардлыг буцаан төлүүлэх акт бичив. Дээрх нь Эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагааны журамд

нийцэхгүй байгаа тул дээрх зардлуудыг холбогдох хүмүүсээр буцаан төлүүлэхээр төлбөрийн акт бичив.

ЭЭСанд зориулагдсан barkod уншигч болон эмийн сангийн тооцооны программыг бүрэн ашиглаж орлого зардалд хяналт тавьж ашиг алдагдлыг зөв тооцож байх шаардлагатай банья. ЭЭСан нь алдагдалтай ажиллах үндэслэлгүй бөгөөд ЭМТ-ийн зардлыг нөхөх зорилготой туслах байгууллага биш юм. Цаашид эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 9 хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн хяналтын талаар удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн. Эдгээр асуудлуудыг Аудитын газар болон Мөнгөнморьт сумын ЭМТөвийн удирдлага авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн болно.

Залруулагдаагүй алдаа

6. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын Газар аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч 7733.3 мянган төгрөгийг аудитын явцад залруулсан болно

Тайлбар мэдүүлгийн захидал

7. Аудитын үйл явцад ААГ хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн ажилтнаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

8. Аймгийн Аудитын газраас тус тайланд ЭЭСангийн хувьд хязгаарлалттай санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Үндэсний Аудитын Газрын Харьяа Аймгийн Аудитын газар

2014.03.16